

## Монгол улсын ядуурлын төлөв байдал

*Б. Энхцэцэг (Ph.D), МУИС, ЭЗС-ийн Хүн амын сургалт, судалгааны төвийн ахлах багш*

Шилжилтийн үеийн тогтворгүй байдлаас хөгжил дэвшлийн үед ирж буй Монголын эдийн засагт эерэг байдал ажиглагдах болов. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт тогтворжих хандлагатай байгаа хэдий ч ядуурал, ажилгүйдлийн хэмжээ дорвитой буурахгүй байна. Хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээ урьд оныхтой харьцуулахад 2006 онд 70 орчим хувиар нэмэгдсэн байна. Ядуурлын хамралт хот, суурин газартай харьцуулахад хөдөөд илүү байна. Монгол улсын ажилгүйдэл нь хэдийгээр зарим үзүүлэлтээр буурч байгаа боловч зохиомол шинжтэй байна. Хөдөөгийн хүн ам зах зээлээс алслагдсаны зэрэгцээ дэд бүтэц хөгжөөгүй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, ажлын байрны хомсдолтой, мэдээллээс түргэн шуурхай хүртэх боломжгүй байгаа нь тэдний амьдралын түвшингийн доройтолд нөлөөлж байна. Ялангуяа, байгаль цаг уурын нөлөөллөөс хараат аж ахуй, амьдралын хэв маяг зонхилж байгаа нь хөдөөгийн хөгжлийн гол хүндрэл болж байна. Монгол улс ядуурлыг бууруулах талаар хүч чармайлт тавьж байгаа хэдий ч түүний хувь хэмжээ олигтой буурахгүй байна. Ядуурлын талаар хийгдсэн судалгаануудын үр дүнгээс үзвэл Монгол дахь ядуурлын хүрээ, цар хэмжээ, орлогын ядуурлын хувьд нэмэгдээгүй харин орлогын тэгш бус байдал нэмэгдсэн байна. Аль ч үзүүлэлтийг авч үзсэн ядуурлыг бууруулах асуудал нь улс орны өмнө тулгарсан чухал сорилт болж байна.

Монгол улс ядуурлын түвшинг 1990-2015 оны хооронд 2 дахин бууруулахын тулд: i) эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ii) ядуурлын гүнгийрэлтийг багасгах, iii) дэд бүтцийг хөгжүүлэх, iv) хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, v) нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон нийгмийн халамж, асрамж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа нийгмийн эмзэг хэсгийн нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах баталгааг сайжруулах, vi) нийгмийн даатгалын төрөл, сонголтыг нэмэгдүүлэх замаар хамрах хүрээг өргөжүүлж, иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах гол арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

*Түлхүүр үгс. Ядуурал, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл*

*Б. Энхцэцэг миний бие Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтуудын 2005-2006 оны хэрэгжилт: Үндэсний хоёр дахь илтгэлийг бичих ажилд судлаачаар ажиллаж, Мянганы хөгжлийн зорилт 1: Ядуурал өлсгөлөнг бууруулах зорилт дээр ажилласан бөгөөд судалгааныхаа хэсгээс энэхүү өгүүлэлд оруулсныг дурьдах нь зүйтэй болов уу.*

Өнөөдөр дэлхий дахинаа хүний хөгжил, ядуурлын асуудлуудад ихээхэн анхаарал хандуулж, улс үндэстний хөгжлийн хамгийн гол хэмжүүр үзүүлэлтүүд болгон ашиглаж байна. 1990-ээд оны эхэн үеийн нээлттэй, зах зээлийн эдийн засгийн эхлэл нь Монголчуудад олон боломж, сонголтыг өгсөн. Гэвч үүний зэрэгцээ эдийн засгийн шилжилт нь нийгмийн зарим бүлгийн хувьд ажилгүйдлийг нэмэгдүүлснээр ядуурлыг бий болгож, амьжиргааны түвшин буурах, нийгмийн тэгш бус байдал эрчимжих, боломж

хязгаарлагдахад хүргэж улмаар нийгмийн баялгаас хүртэх хүртээмжид ялгавартай байдал үүсэхэд хүргэсэн.

Шилжилтийн үеийн тогтворгүй байдлаас хөгжил дэвшлийн үед ирж буй Монголын эдийн засагт эерэг байдал (Дотоодын Нийт Бүтээгдэхүүний хувьд) ажиглагдах боллоо. 2002 онд ДНБ-ний өсөлт 4.0 хувь байсан бол 2004 онд 10.7 хувь болж өссөн бөгөөд 2005 онд бууран 6.2 хувь болжээ. 2006 оны урьдчилсан дүнгээр ДНБ-ний өсөлт 8.4 хувь байхаар тооцоо гарсан. Оны үнээр нэг хүнд ногдох Үндэсний Нийт



Хүснэгт 1: Монгол улсын эдийн засгийн үзүүлэлт

Он	Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) (%)	Нэг хүнд ногдох ҮНО (ам.доллар)
2002	4.0	446
2003	5.6	509
2004	10.7	655
2005	6.2	744
2006	8.4	1037

Эх үүсвэр: ҮСГ (2006), Монгол улсын Статистикийн эмхэтгэл 2005, Улаанбаатар хот

Орлогын (ҮНО) хэмжээ 2005 онд 744 ам.доллар, 2006 оны урьдчилсан дүнгээр 1037 орчим ам.доллар буюу нэг жилийн дотор 300 орчим ам.доллараар өссөн дүн гарч байна (ҮСГ 2006).

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт тогтворжих хандлагатай байгаа

төсөвт байгууллагад ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх замаар иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэх, цалингаараа амьдрах нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлж байна.

Өрхийн амьжиргааны түвшин, ядуурлын

Хүснэгт 2: Хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, төсөвт байгууллагад ажиллагсдын дундаж цалингийн зэрэгцүүлэлт, сард нэг хүнд ногдохоор (төгрөгөөр)

Он	Хүн амын амьжиргааны баталгаажих түвшин, бүсээр					Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	Төсөвт байгууллагад ажиллагсдын дундаж цалин
	Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	УБ хот		
2001	18 200	18 200	19 300	19 900	23 600	24 750	57 600
2002	19 200	19 100	19 700	20 200	24 600	30 000	64 600
2003	19 500	19 900	19 800	20 500	25 300	30 000	71 500
2004	20 200	20 600	20 600	21 200	26 500	40 000	88 900
2005	23 200	22 600	22 300	25 000	30 000	42 500	98 600
2006	37 000	38 300	39 000	34 800	42 800	53 000	128 400

Эх үүсвэр: ҮСГ (2007), Монгол улсын Статистикийн эмхэтгэл 2006, Улаанбаатар хот

хэдий ч ядуурал, ажилгүйдлийн хэмжээ дорвитой буурахгүй байна. Монгол улсын амьжиргааны доод түвшингээс доогуур амьжиргаатай хүн амын хувийн жин 1990 онд 36.3 хувь, 2000 онд 35.6 хувь, 2005 онд 36.1 хувь байснаа 2006 оны эцэс гэхэд 32.2 хувь болжээ.

Монголд ядуурлын хэмжээг тогтоохдоо ядуурлын шугам буюу амьжиргааны доод түвшинг ашиглаж байна. ҮСГ-аас хүн амын амьжиргааны доод түвшинг 1998 оноос эхлэн бүс нутгаар үнэ тарифын өөрчлөлт, инфляцын түвшинг харгалзан тодорхойлж, зарлаж байна.

Хүснэгт 2-оос харахад Хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээ урьд оныхтой харьцуулахад 2006 онд 70 орчим хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ,

байдлыг тодорхойлох зорилгоор 2002-2003 онд өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшингийн түүвэр судалгааг явуулж улмаар 2006 онд өрхийн орлого, зарлагын судалгааг сайжруулж ядуурлын түвшинг тооцон гаргажээ. Ядуурлын гүнзгийрэлт 2002-2003 онд 11.0 байснаа 2006 онд 10.1 хувь болсон нь ядуучуудын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамны дунджаас 10 хувиар доогуур байгааг харуулж байна. Ядуурлын мэдрэмжийн индекс 4.5 хувь байна.

Ядуурлын хамралт хот, суурин газартай харьцуулахад хөдөөд илүү байна. Хөдөөгийн хүн ам зах зээлээс алслагдсаны зэрэгцээ дэд бүтэц хөгжөөгүй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, ажлын байрны хомсдолтой, мэдээллээс түргэн шуурхай хүртэх боломжгүй байгаа нь тэдний

амьдралын түвшингийн доройтолд нөлөөлж байна. Байгаль цаг уурын нөлөөллөөс хараат аж ахуй, амьдралын хэв маяг зонхилж байгаа нь хөдөөгийн

тавны нэг орчим нь ядуу байна. Энэ нь дэд бүтэц хөгжсөн, худалдаа наймаа эрхлэх, ажил эрхлэх боломж төв суурин газарт илүү байгаатай холбоотой.

Хүснэгт 3: Ядуурлын үндсэн үзүүлэлт

Он	Ядуурлын гүнгийрэлт	Ядуурлын мэдрэмж	Жини коэффициент
2002-2003	11.0	4.7	0.329
2006	10.1	4.5	0.380

Эх үүсвэр: УСГ (2007), Монгол улсын Статистикийн эмхэтгэл 2006, Улаанбаатар хот

хөгжлийн гол хүндрэл болж байна. Хөдөөд 1999-2003 онд үргэлжлэн болсон зудын уршгаар 11.4 сая толгой мал буюу нийт малын 25 хувь хорогджээ.

Хотын ядуурлын хэмжээ 2003-2006 онд 30.3 хувиас 27.0 хувь, хөдөөгийн ядуурал 43.4 хувиас 37 хувь хүртэл буурчээ. Ядуурлын хамралтын хүрээ 2002-2003 онд Монгол улсын баруун бүсэд өндөр буюу 51 хувь, Хангайн бүсэд 39 хувь, Зүүн бүсэд 35 хувь, Төвийн бүсэд 34 хувь байсан бол 2006 онд ядуурлын хэмжээ Баруун бүсэд хамгийн эрчимтэй буюу 39 хувь болж буурчээ.

Баруун бүсэд 2005, 2006 онд 503.1 сая төгрөгийн санхүүжилттэй нийт 148

Хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээ үндэсний нийт хэрэглээнд 7.5 хувийг эзэлж байхад хамгийн чинээлэг хүн амын хэрэглээ 40.4 хувь, өөрөөр хэлбэл, хүн амын хамгийн чинээлэг (20 хувь) хэсгийн хэрэглээний дундаж хэмжээ ядуу (20 хувь) хэсгийнхнээс 5.5 дахин өндөр байна.

Орлогын тэгш бус хуваарилалтыг Жини коэффициентээр хэмжихэд 1998 онд 0.350, 2002-2003 онд 0.329 байснаа 2006 онд 0.380 болж өссөн нь орлого хуваарилалтын тэгш бус байдал нэмэгдэж буйг харуулж байна.

Хүснэгт 4: Ядуурлын хамралтын хүрээ

	2002-2003	2006
Улсын дундаж	36.1	32.2
<i>Байршлаар</i>		
Хот	30.3	27.9
- Улаанбаатар	27.3	20.4
- Аймгийн төв	33.9	36.1
Хөдөө	43.4	37.0
<i>Бүс нутгаар</i>		
Баруун	51.1	38.7
Хангай	38.7	37.7
Төв	34.4	34.0
Зүүн	34.5	36.5
Улаанбаатар	27.3	20.4


Эх үүсвэр: УСГ, "Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа 2002-2003" УСГ, "Өрхийн орлого, зарлагын судалгаа, 2006"

төсөл хэрэгжүүлсэн нь энэхүү бууралтад нөлөөлсөн болов уу. Харин бусад бүсэд ядуурлын бууралт харьцангуй бага байна. Улаанбаатар хотын хувьд бусад бүсүүдтэй харьцуулахад ядуурлын хамралтын хүрээ хамгийн бага буюу нийслэлийн хүн амын

"Оролцооны аргаар ядуурлын байдалд дүн шинжилгээ хийх нь" 2005 оны судалгаанд оролцогчид ядуучуудын тоо нэмэгдсээр байна, цаашдаа ч өсөх хандлагатай гэжээ. Энэ судалгааны дүгнэлт нь амьжиргааны түвшингийн судалгааны дүнгээс өөр бай-



Зураг 1: Хүн амын хэрэглээний бүтэц, тэнцүү 5 бүлгээр



Эх үүсвэр: УСГ, "Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа 2002-2003"

гаань уг судалгаанд нийгмийн ядуу бүлгийн төлөөллийг илүү сонгож хамруулсантай холбоотой. Уг судалгаанд оролцогчид ядуурлын гүнзгийрэлт ч нэмэгдэж байгааг тэмдэглэжээ. Зуд болон байгалийн бусад гамшгийн улмаас хөрөнгө, түүний дотор орон гэргүй болсон, тэжээгчээ алдсан, асран хамгаалах хүнгүй, хөгжлийн

**Ядуурлын шалтгаан**

Монгол улс зах зээлийн тогтолцоонд шилжсэнээс хойш 15 гаруй жилийн хугацаа өнгөрч байна. Энэхүү шилжилтийн үе дотоод, гадаад олон хүчин зүйлээс шалтгаалсан өөрийн гэсэн сөрөг үр дагавруудыг авчирсан бөгөөд ард түмний

Хүснэгт 5: Тэгш бус байдлын үзүүлэлт

	Жини коэффициент		
	1998	2002-2003	2006*
<b>Улсын дундаж</b>	0,350	0,329	0,380
Хот	-	0,331	0,386
Хөдөө	-	0,313	0,360
<b>Бүс</b>			
Баруун	-	0,306	0,342
Хангай	-	0,320	0,354
Төв	-	0,314	0,393
Зүүн	-	0,317	0,399
Улаанбаатар	-	0,332	0,367
<b>Суурьшил</b>			
Улаанбаатар	-	0,332	0,367
Аймгийн төв	-	0,324	0,389
Сумын төв	-	0,318	0,373
Хөдөө	-	0,309	0,346

Эх үүсвэр: УСГ (2007), Монгол улсын Статистикийн эмхэтгэл 2006, Улаанбаатар хот

бэрхшээлтэй хүмүүс, өндөр настан болон ганц бие өрх толгойлсон хүмүүс зэрэг нь нийгмийн хамгийн эмзэг бүлэг болж хувирсныг тодорхойлсон байна.

амьжиргаанд мэдэгдэхүйц өөрчлөлтийг бий болгосон. Монгол дахь ядуурал нь ажил эрхлэлттэй шууд холбоотой. Монгол улсын ажилгүйдлийн түвшин 1990-1995 онд 6.5 хувь, 1997 онд 7.5, 1998 онд 5.8 хувь байснаа 2005 онд 3.3 хувь болж буурчээ.

Монгол улсын хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгэлтэй ажилгүйчүүд 1995 онд 45.1 мянга, 1998 онд 49.8 мянга, 2005 онд 32.9 мянга байна. Харин хөдөлмөр эрхлээгүй хүн 1996 онд 227.1 мянга, 1998 онд 221.4 мянга, 2005 онд 200.0 гаруй мянга байна. Ийнхүү Монгол улсын ажилгүйдэл нь хэдийгээр зарим үзүүлэлтээр буурч байгаа боловч зохиомол шинжтэй байна. Энд нөлөөлж байгаа шалтгаанууд нь хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн ажилгүйчүүд 3 сараас дээш хугацаанд эргэж ирээгүй бол ажилгүйчүүдийн тооноос хасч байгаа журам, ажилгүйчүүдийн тоонд орж бүртгүүлснээр тухайн хүнд үр нөлөө үзүүлэх нь тун бага байгаа явдал, статистикийн ялангуяа хөдөлмөрийн статистикийн мэдээ бүртгэл төдийлөн сайн биш байгаа зэрэгтэй холбоотой (Н. Содномдорж, 2006).

Ядуурлын түвшин улсын дүнгээр нэмэгдээгүй ч ядуурлын шинж байдал, шалтгаан хот хөдөөд харилцан адилгүй байна. Хөдөөгийн хүн ам зах зээлээс алслагдсаны зэрэгцээ дэд бүтэц хөгжөөгүй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, ажлын байрны хомсдолтой, мэдээллээс түргэн шуурхай хүртэх боломжгүй байгаа нь тэдний амьдралын түвшингийн доройтолд нөлөөлж байна. Ялангуяа, байгаль цаг уурын нөлөөллөөс хараат аж ахуй, амьдралын хэв маяг зонхилж байгаа нь хөдөөгийн хөгжлийн гол хүндрэл болж байна. Хөдөөд 1999-2003 онд үргэлжлэн болсон зудын уршгаар мал сүргээ бүгдийг эсвэл ихэнхийг нь хорогдуулсан хүмүүс амьдралын эх үүсвэргүй үлдсэн. Энэ нь хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөний урсгалыг бий болгосон. 1999-2003 оны хооронд хөдөлмөр эрхлэх боломжийг хайх болон боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд ойртох зорилгоор хийсэн шилжих хөдөлгөөнөөс хамааран нийслэл хотын хүн амын тоо 27.5 хувиар өсчээ (НҮБХХ 2004).

Хотод амьдарч буй хүн амын эзлэх хувь жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 2000 оны байдлаар хот сууринд нийт хүн амын 57 хувь амьдарч байсан бол 2005 онд 60.2 хувь, үүнээс 38 хувь нь Улаанбаатар хотод харьяалагдаж байна.

Монгол дахь ядуурал нь дийлэнхдээ орлогын хомсдлоос үүдэлтэй байгаа ба амьжиргааны тогтмол орлогын эх үүсвэргүй байдал нь ядуурал гүнзгийрэх бас нэг гол шалтгаан болж байна. Монголын хүн амын орлогын 35 хувийг цалин, 33 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 11 хувийг тэтгэвэр, тэтгэмж, үлдсэн 20 гаруй хувийг өөрийн хувийн аж ахуй, бусдаас үнэгүй авсан зүйлсээс бүрдэж байна. Гэхдээ энэ нь өрхийн байршлаас ихээхэн хамааралтай байна. Хотын өрхийн орлогын 50-иас илүү хувийг цалин хөлс бүрдүүлж байхад, хөдөөгийн өрх орлогынхоо 50 орчим хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос бүрдүүлж байна (ҮСГ, 2007).

#### *Ядуурлын түвшний харьцуулалт*

Дэлхийн хүн амын илтгэл 2002-д тэмдэглэснээр ядуурлын бууралт дэлхийн бүс нутаг, улс орнуудад харилцан адилгүй байна. Жишээ нь, Зүүн Азийн орнуудад, ялангуяа Хятад улсад ядуурал хурдацтай буурсан бол Зүүн Европын болон Төв Азийн орнуудад ядуурал өсчээ. Өмнөд Ази болон Африкийн орнуудад мөн ядуурал нэмэгдсэн бол Ойрхи Дорнод хийгээд Латин Америкийн орнуудад ядуурал бага хэмжээгээр буурч байна.

Ази, Номхон далайн орнуудыг авч үзвэл, ядуурлын тархалт Зүүн Ази, Зүүн Өмнөд Ази болон Номхон далайн бүсийн орнуудад 1990 оноос хойш эрчимтэй буурч 2015 он гэхэд ядуурлыг тэн хагасаар бууруулах Мянганы Хөгжлийн Зорилгод (МХЗ) бараг хүрээд байгаа бөгөөд цаашид энэхүү амжилтаа хадгалахыг зорьж байна. Харин Өмнөд Азийн бүсийн орнуудад ядуурлын бууралт маш удаан явагдаж байгаа бөгөөд МХЗ-ийг биелүүлж чадах



эсэх нь нэлээд эргэлзээтэй байна. Зүүн Европ болон Төв Азийн /Монголыг оролцуулан/ шилжилтийн эдийн засагтай орнуудад 1990 оноос эхлэн ядуурлын түвшин огцом нэмэгдсэн тул 1990 оны ядуурлын өндөр түвшинг 2 дахин бууруулах нь нэлээд хэцүү зорилт болоод байна.

Улс орнуудад ядуурлын шугам буюу амьжиргааны баталгаажих доод түвшинг өөр өөр аргачлал ашиглан тогтоодог хэдий ч улс орнуудын харьцуулалтыг хийхэд энэхүү үндэсний ядуурлын шугамыг ашиглаж болох юм. Ялангуяа, 1 ам долларын ядуурлын шугамыг ашиглан ядуурлын түвшинг тооцож гаргадаггүй улс орнууд үндэсний ядуурлын шугамыг ашиглан 1990 оноос 2015 он гэхэд ядуурлыг 2 дахин бууруулах зорилтыг хэмжих юм.

Ядуурлын түвшинг харуулсан тоо мэдээллийн боломжтой байдлаас шалтгаалан Азийн зарим орнуудын ядуурлын түвшний өсөлт, бууралтын хандлагыг суурь он болон өнөөгийн байдлаар харьцуулж МХЗ-ийн 2015 оны зорилтдоо хүрэх боломжтой эсэхийг НҮБ-аас боловсруулсан үнэлгээний аргачлалаар сонгогдсон Азийн орнуудын хувьд тооцож үзлээ. Тооцооны дүнгээс харахад Хятад, Малайз, Тайланд улсууд ядуурлын түвшинг 2 дахин бууруулах зорилтдоо бараг хүрээд байна. Харин Индонез улсад 1997-1998 оны санхүүгийн хямралтай байдлаас шалтгаалан ядуурлын түвшин нэмэгдсэн учир ядуурлыг

бууруулах зорилтыг биелүүлэх боломжгүйд хүрээд байна. МХЗ-ийг 2 дахин бууруулах боломжтой байгаа Бангладеш, Энэтхэг зэрэг оронд ядуурлын түвшнийн бууралт харьцангуй хурдан байхад Монголд ядуурлын бууралтын хувь нэлээд удаан байна.

### Ядуурлыг бууруулах Засгийн газрын бодлого

Хүн амын ядуурлыг 2015 он гэхэд тэн хагасаар бууруулах МХЗ-д хүрэхэд 10 хүрэхгүй жил үлдээд байгаа ба ядуурлыг бууруулах асуудал дэлхийн бүх улс орнуудын тулгамдсан асуудал болж байна. Монгол улсын хувьд ядуурлын түвшин 1990-2000 оны хоорондох арван жилийн хугацаанд ердөө 0.7 хувиар, 2002-2006 оны хоорондох 5 жилийн хугацаанд 3.5 хувиар тус тус буурчээ. Тэгвэл 2015 оны хооронд ядуурлын түвшинг яаж хоёр дахин бууруулах вэ?

Хэдийгээр ядуурлын түвшин дорвитой буурахгүй байгаа ч хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах нь Монгол Улсын Засгийн газрын нийгмийн салбарын чухал зорилт болж байгаа ба энэ чиглэлээр тодорхой бодлого баримталж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг мөрдөж ирсэн.

Хүснэгт 6: Азийн зарим улс орнуудын МХЗ I-ийг биелүүлэх боломж

Улс	Суурь он		Зорилго		Хүрсэн түвшин		МХЗ-ийг биелүүлэх боломж
	Он	хувь	2015 он	хувь	2006 он	хувь	
Бангладеш	1990	47.8	2015	24	2000	34	Боломжтой
Хятад	1990	9.4	2015	5	1999	3.7	Бараг биелүүдсэн
Энэтхэг	1990	38.9	2015	19	1999	26.1	Боломжтой
Индонез	1990	15.1	2015	8	1999	18.2	Боломжгүй
Малайз	1990	17.1	2015	9	1999	8.1	Бараг биелүүдсэн
Монгол	1990	36.1	2015	18	2006	32.2	Боломжтой
Непал	1990	41.4	2015	21	2004	30.9	Боломжтой
Өмнөд Солонгос	1990	8.4	2015	4	1996	7.0	Боломжтой
Тайланд	1990	27.2	2015	14	1999	15.9	Бараг биелүүдсэн

Эх үүсвэр: Дэлхийн Банк (2001), Дэлхийн Хөгжлийн тайлан



*Ядуурлыг бууруулах хөтөлбөр, төслүүд*

Ядуурлыг бууруулах хүрээнд Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг, Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын чанартай олон баримт бичгүүдийг Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байна.

Ядуурлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийн үргэлжлэл болох Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2003 оноос Дэлхийн банкны 18.6 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл Монгол Улсын Засгийн газрын 3.4 сая ам. долларын нийт 22 сая ам. долларын өртөг бүхий “Тогтвортой амьжиргаа” төсөл, АХБ-ны 16.0 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэн хэрэгжиж буй Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр, Шведийн Олон Улсын хөгжлийн агентлаг НҮБХХ-ийн 1.5 сая ам. долларын буцалтгүй тусламжаар санхүүжин хэрэгжсэн Ядуурлын судалгаа ба хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл зэргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас ядуурлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ баримталж байгаа үндсэн зарчим бол ядуу иргэдэд улсаас бэлэн тусламж, дэмжлэг олгохоос аль болох зайлсхийж, тэдэнд биеэ дааж амьдрах нөхцөл бололцоог баталгаатай бий болгох явдал юм. Хөдөлмөр эрхлэх болон гэр бүлийнхээ наад захын хэрэгцээг хангахуйц орлогын бусад найдвартай эх үүсвэртэй болох нь ядуурлаас гарах хамгийн чухал арга зам юм. Иймд төрөөс хот, хөдөөд эдийн засгийн бүх салбарт ажиллаж байгаа ажиллагчдын зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого барьж, хэрэгжүүлэхэд анхаарч байна.

Хэдийгээр төсвийн санхүүжилт бүрэн хангалттай бус байгаа ч хүнамын нийгмийн

хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн үүргийн үзэл баримтлалыг боловсруулж, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт шинэчлэл хийх замаар Монгол Улс эдийн засгийн шинэ харилцаанд нийцсэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг бий болгож хөгжүүлэхийг зорьж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилттой уялдуулж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хэрэгжүүлэх зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулж УИХ-аар батлуулсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид болон малчдыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах, үйлчилгээний шинэ хэлбэрийг нэвтрүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг асуудлаар чухал заалтууд тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн дээрх бодлого, арга хэмжээний үр дүнд хүн амын мөнгөн орлого нэмэгдэж, айл өрх бүрт зохих хөрөнгө оруулалт хийгдэж байна. Түүнчлэн төсвөөс олгодог цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг удаа дараа нэмэгдүүлэх арга хэмжээг авсан. Одоогоор эдгээр бодлого, хөтөлбөрийн үр өгөөжийн талаар хийгдсэн сүүлийн үеийн албан ёсны тоо мэдээ, судалгааны ажил хараахан хийгдээгүй байна.

Ийнхүү Монгол улс ядуурлыг бууруулах талаар хүч чармайлт тавьж байгаа хэдий ч түүний хувь хэмжээ олигтой буурахгүй байна. Ядуурлын талаар хийгдсэн судалгаануудын үр дүнгээс үзвэл Монгол дахь ядуурлын хүрээ, цар хэмжээ, орлогын ядуурлын хувьд нэмэгдээгүй харин орлогын тэгш бус байдал нэмэгдсэн байна. Аль ч үзүүлэлтийг авч



үзсэн ядуурлыг бууруулах асуудал нь улс орны өмнө тулгарсан чухал сорилт болж байна.

*Ядуурлыг бууруулахын тулд шийдвэрлэх асуудал*

Монгол улсын Засгийн газраас ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөр, төсөл, судалгаа хийж байгаа нь тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгсөөр байгаа боловч ядуурал дорвитой буурахгүй байна. Ядуурал нь хүн амын бодит орлого, амьжиргааны түвшин буурснаар илэрч байгаа төдийгүй эрүүл мэнд муудах, боловсрол, соёлын үйл ажиллагаа хямрах, хүүхэд сургууль завсардах, гэр бүл салах, гэмт хэрэг өсөх зэрэг сөрөг үр дагавартай байна.

Ядуу орлого багатай иргэдийн амьжиргааг сайжруулах замаар ядуурлаас гаргах гол арга зам нь тэднийг “ажлаар хангах” зорилтыг тууштай дэвшүүлэн хэрэгжүүлэх явдал юм. Ядуурлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ядуу иргэдэд орлогын байнгын эх үүсвэртэй, биеэ дааж амьдрах нөхцөл бололцоог баталгаатай бий болгох зарчим баримтлахын зэрэгцээ нийгмийн дэмжлэгт сулалцаа зайлшгүй шаардлагатай хүн амын бүлгүүдэд нийгмийн халамж, асрамж, үйлчилгээний хүрээг өргөтгөх шаардлагатай.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол улс ядуурлын түвшинг 1990-2015 оны хооронд 2 дахин бууруулахын тулд: i) эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ii) ядуурлын гүнгийрэлтийг багасгах, iii) дэд бүтцийг хөгжүүлэх, iv) хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, v) нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон нийгмийн халамж, асрамж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа нийгмийн эмзэг хэсгийн нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах баталгааг сайжруулах, vi) нийгмийн даатгалын төрөл, сонголтыг нэмэгдүүлэх замаар хамрах хүрээг өргөжүүлж иргэдийн нийгмийн баталгааг

сайжруулах гол арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

*Ашигласан материал*

Монгол Улсын Засгийн Газар, НҮБХХ (2003). Монголын хүний хөгжлийн илтгэл 2003, Улаанбаатар хэвлэлийн “Мөнхийн үсэг” компани

Монгол Улсын Засгийн Газар, НҮБХХ (2004). Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, Улаанбаатар

Н. Содномдорж (2006). Монгол улсын ажил эрхлэлт ба хөдөлмөрийн зах зээл, Хүний хөгжлийн илтгэл-2006 –д зориулсан өгүүлэл

А. Солонго, Б. Мөнхжаргал (2003). Бүс нутгууд дахь хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын асуудлууд, Монголын хүн амын сэтгүүл дугаар 8, хуудас 29- 45

Б. Сувд болон бусад (2003). Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлын үнэлгээ. Монгол, Улаанбаатар

ҮСГ, НҮБХХ (1999). Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1998, Улаанбаатар

ҮСГ, Дэлхийн банк, НҮБХХ (2004). Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа, Улаанбаатар хэвлэлийн “Адмон” компани

ҮСГ, АХБ, ДБ (2005). Монгол Улс Оролцооны аргаар ядуурлын байдалд дүн шинжилгээ хийх нь, Улаанбаатар

ҮСГ, (2007). Монгол улсын Статистикийн эмхтгэл 2006, Улаанбаатар



## Монгол орны баруун бүсийн хүн ам зүйн орчны судалгаа

Б.Дэмид, (Ph D), дэд проф.  
Д.Алтанхуяг, магистр

Монголын хүн ам зүйн байдлыг тодорхой чиглэлээр, хэсэгчилсэн байдлаар судалж байснаас хүн ам зүй, түүний хөгжлийн асуудлыг цогц байдлаар дагнан судалсан дорвитой судалгаа хараахан үгүй байна. Энэхүү судалгаандаа хүн ам зүйн хөгжлийн үндсэн параметрууд болох хүн амын бүтэц, хүн амын төрөлт, нас баралт, дундаж наслалт, өсөлт, өрхийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн зэрэг үзүүлэлтүүдээс гадна бүсийн хүн амын боловсрол, хөдөлмөрийн нөөц чадавхи, ажил эрхлэлт, ажлын байр, мөн тус бүсийн хөгжил, бүтээн байгуулалтын талбарт шаардлагатай мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж, мэргэжил, ажилгүй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгож ажлын байраар хангаж буй байдал гэсэн үзүүлэлтүүдийг сонгон авч харьцуулан судалсан болно. Судалгааны үр дүнгээс харахад өнөөдөр хүн амын судалгааг зөвхөн тоо хэмжээ, төрөлт, нас баралт, дундаж наслалт гэх мэтийн тогтсон хэдэн үзүүлэлтийн хүрээнд эргэлдэх бус хүн ам зүйн байдлыг олон өнцгөөс нь харж, олон хэмжүүрээр авч үзэж, гол нь улс орны эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлүүдтэй уялдуулан авч судлах шаардлага нэн чухлаар тавигдаж байна.

Өргөн уудам нутагтай, тархай бутархай суурьшсан цөөхөн хүн амтай, буурай хөгжилтэй, ядуурал, шилжилт хөдөлгөөн ихтэй атлаа өнөөгийн нээлттэй дэлхий ертөнц, даяаршилын орчин нөхцөлд татагдан орохоос өөр арга үгүй болсон манай орны хувьд хүн ам зүйн бодлогодоо шинэчлэл хийж, хүн амын өсөлтийг тууштай дэмжсэн даацтай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

*Түлхүүр үгс.* Хүн ам зүй, нас хүйсийн бүтэц, хүн амын өсөлт, боловсрол, ажил эрхлэлт

Манай улсын хүн ам зүйн судалгааны түүхийг авч үзэхэд одоогоос 40 жилийн тэртээ буюу өмнөх нийгмийн тогтолцооны үед хүн ам зүйч, эрдэмтэн Р.Гүр уг асуудлыг анх судлаж, “БНМАУ-ын хүн ам “гэдэг бүтээлээ нийтийн хүртээл болгосон байна. Тэр үеэс хойш хэсэг хугацаа тасарсны дараагаар эрдэмтэн М.Баянтөмөр, Д.Базаргүр, Б.Гунгаадаш, О.Сүхбаатар, Х.Цэдэнсодном нар монголын хүн амын байршил, сууршил, шилжилт хөдөлгөөний байдлыг эдийн засгийн газарзүйн үүднээс эрдэмтэн Д.Бямбасүрэн, Н.Болдбаатар, Т.Дорж, Д.Лхаашид, Д.Мягмар, П.Нэргүй, Н.Содномдорж, Я.Шуурав нар хүн амын хөдөлмөрийн нөөц, ажил эрхлэлтийн талаас, эрдэмтэн П.Гансүх нар хүн ам зүйн менежментийн талаас судалсан байна. Сүүлийн жилүүдэд хүн амын судалгаанд “нөхөн үржихүй” гэсэн чиглэл бий болж, хүн амыг эрүүл мэндийн талаас нь гол төлөв гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд эмч, социологийн

ажилтнууд судалгаа хийх болсон байна. Мөн манай орны хүн ам зүйн судалгаанд Америкийн монголч эрдэмтэн Латтимор, Данийн монголч эрдэмтэн Хеннин Хаслунд Крестенсин, Оросын монголч эрдэмтэн И.М.Майский, Г.С.Матвеева, С.К.Рошин, В.В.Гай нарын эрдэмтэд томоохон хувь нэмэр оруулсан байна.

Гэхдээ монголын хүн ам зүйн байдлыг тодорхой чиглэлээр, хэсэгчилсэн байдлаар судалж байснаас хүн ам зүй, түүний хөгжлийн асуудлыг цогц байдлаар дагнан судалсан дорвитой судалгаа хараахан үгүй байна.

Хүн ам зүйн асуудлыг нэг хэсэг судлаачид гурван халимны дээрх дэлхийтэй адил буюу төрөлт, нас баралт, урт наслалт гурав дээрх “таваг” гэж үздэг бол нөгөө хэсэг судлаачид дээрх 3 үзүүлэлт дээр гэрлэлт гэр бүлийг нэмж, “4 хөлт ширээ” – тэй зүйрлэн үздэг байна. Гэтэл зарим судлаачид хүн ам зүйн хөгжлийг нэгэн